

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/127/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых

Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18
4.2 Төлбөрийн акт .....	18
Байхгүй .....	18
4.3 Албан шаардлага .....	18
4.4 Зөвлөмж .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 6 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Т.МАНКЕЙ ТАНАА**

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠑ № 145  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Өлгий-ЕБ-ын-6-dugnelt-2.23-TA

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Өлгий-ЕБ-ын-6-dugnelt-2.23-ТА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>34443024.68</u></b>	<b><u>35463073.18</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3263911.00</b>	<b>4039710.03</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3263911.00	4039710.03
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>31179113.68</b>	<b>31423363.15</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>367600.00</b>	<b>0.00</b>
35130	Эм боох материал	367600.00	0.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7464200.00	6268200.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>23347313.68</b>	<b>25155163.15</b>
35410	Бичиг хэргийн материал	0.00	650000.00
35420	Аж ахуйн материал	5483361.00	5483361.00
35460	Хүнсний материал	0.07	127160.00
35470	Бусад хангамжийн материал	17863952.61	18894642.15
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>295038134.86</u></b>	<b><u>2286429836.86</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>295038134.86</b>	<b>2286429836.86</b>
391	Газар	0.00	0.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>271608134.86</b>	<b>2102999836.86</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	212669880.00	212669880.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12509993.04	-18764989.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	119922091.96	121622091.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-76069570.09	-87137286.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61052557.50	61052557.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47295390.47	-50280975.41
39214	Бусад үндсэн хөрөнгө	5794657.00	5794657.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5794657.00	-5794657.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	1850000000.00
39217	Ном	13838559.00	13838559.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>23430000.00</b>	<b>183430000.00</b>
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23430000.00	183430000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>329481159.54</u></b>	<b><u>2321892910.04</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>7292185.00</u></b>	<b><u>12121009.80</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7292185.00</b>	<b>12121009.80</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	7292185.00	12121009.80
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>322188974.54</u></b>	<b><u>2309771900.24</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>322188974.54</b>	<b>2309771900.24</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249324846.50	409324846.50
51101	Өмч: - төрийн	249324846.50	409324846.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-85489127.31</b>	<b>1742093798.39</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-85489127.31	-85489127.31
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1827582925.70
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	158353255.35	158353255.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>329481159.54</u></b>	<b><u>2321892910.04</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,261,117,383.05</b>	<b>3,112,203,850.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>269,230.00</b>
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	269,230.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,261,117,383.05</b>	<b>3,111,934,620.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,190,090,223.05</b>	<b>3,046,503,400.00</b>
131005	Хөрөнгийн санхүүжилт	8,534,423.05	1,850,000,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,181,555,800.00	1,196,503,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>5,169,620.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,169,620.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>61,057,200.00</b>	<b>60,261,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,057,200.00	60,261,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>9,969,960.00</b>	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,969,960.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,265,836,359.03</b>	<b>1,284,620,924.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,265,836,359.03</b>	<b>1,284,620,924.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,229,947,599.03</b>	<b>1,250,733,424.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>942,699,866.00</b>	<b>949,944,300.97</b>
210101	Үндсэн цалин	846,821,366.00	893,338,900.00
210104	Урамшуулал	95,878,500.00	56,605,400.97
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>117,444,577.00</b>	<b>128,347,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	79,505,049.00	86,582,614.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,658,122.00	9,848,916.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,483,215.00	4,247,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,870,801.00	16,563,212.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,927,390.00	11,104,858.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>57,884,910.13</b>	<b>63,926,583.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,852,861.13	3,464,800.00

210302	Түлш, халаалт	41,695,460.00	48,320,633.80
210303	Цэвэр, бохир ус	13,336,589.00	12,141,150.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,572,005.00</b>	<b>9,147,826.46</b>
210401	Бичиг хэрэг	1,512,300.00	1650294.00
210402	Тээвэр, шатахуун	1,845,000.00	381,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,114,300.00	1191967.00
210404	Ном, хэвлэл	694,800.00	646,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	102,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,405,605.00	5,175,365.46
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>79,027,010.36</b>	<b>72,734,515.07</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	468,700.00	2,285,200.00
210502	Хоол, хүнс	67,298,753.36	69,639,540.07
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,259,557.00	809,775.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,299,999.85</b>	<b>1,392,000.00</b>
210604	Урсгал засвар	1,299,999.85	1,392,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,302,700.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	1,302,700.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>600,000.00</b>	<b>690,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	690,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,116,530.69</b>	<b>24,550,998.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,464,500.00	4,242,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,652,030.69	20,308,298.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,888,760.00</b>	<b>33,887,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,571,060.00</b>	<b>33,887,500.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9,969,960.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,601,100.00	33,887,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,317,700.00</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,317,700.00	-

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(4,718,975.98)	1,827,582,925.70
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(4,718,975.98)	1,827,582,925.70

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн		Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	249,324,846.50	158,353,255.35	-85,489,127.31		322,188,974.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,324,846.50	158,353,255.35	-85,489,127.31		322,188,974.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,324,846.50	158,353,255.35	-85,489,127.31	0	322,188,974.54
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	249,324,846.50	158,353,255.35	-85,489,127.31	0	322,188,974.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,324,846.50	158,353,255.35	-85,489,127.31	0	322,188,974.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	160,000,000.00				160,000,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,827,582,925.70		1,827,582,925.70
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	409,324,846.50	158,353,255.35	1,742,093,798.39	0	2,309,771,900.24

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1252582960.00</b>	<b>1261934620.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1252582960.00</b>	<b>1261934620.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1181555800.00</b>	<b>1196503400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1181555800.00	1196503400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>5169620.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5169620.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>61057200.00</b>	<b>60261600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61057200.00	60261600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>9969960.00</b>	<b>0.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9969960.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1242519060.00</b>	<b>1260234620.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1242519060.00</b>	<b>1260234620.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1206630300.00</b>	<b>1226347120.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>934797700.00</b>	<b>950720100.00</b>
210101	Үндсэн цалин	838788000.00	894448600.00
210104	Урамшуулал	96009700.00	56271500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>117831700.00</b>	<b>128347200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	82918600.00	90318500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8728300.00	9507100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6982600.00	7605700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1745700.00	1901400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17456500.00	19014500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61057200.00</b>	<b>59261600.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5464800.00	4464800.00
210302	Түлш, халаалт	43482400.00	42686800.00
210303	Цэвэр, бохир ус	12110000.00	12110000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8142100.00</b>	<b>8674020.00</b>
210401	Бичиг хэрэг	955300.00	3112394.00
210402	Тээвэр, шатахуун	1845000.00	1530000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1114300.00	1874126.00
210404	Ном, хэвлэл	694800.00	746800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		102400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3532700.00	1308300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>78991100.00</b>	<b>73393000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	468700.00	422400.00
210502	Хоол, хүнс	67360000.00	69782700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11162400.00	3187900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>1000000.00</b>
210604	Урсгал засвар		1000000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1302700.00</b>	<b>373400.00</b>
210702	Дотоод албан томилолт	1302700.00	373400.00

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>600000.00</b>	<b>1066700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		466700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3907800.00</b>	<b>3511100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3907800.00	3511100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35888760.00</b>	<b>33887500.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22571060.00</b>	<b>33887500.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9969960.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12601100.00	33887500.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13317700.00</b>	<b>0.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13317700.00	
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>10063900.00</b>	<b>1700000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>1700000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1700000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>-1700000.00</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	10063900.00	0.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1256765000.00</b>	<b>1256765000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1256765000.00</b>	<b>1256765000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1222877500.00</b>	<b>1222877500.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>950720100.00</b>	<b>950720100.00</b>
210101	Үндсэн цалин	894448600.00	894448600.00
210104	Урамшуулал	56271500.00	56271500.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>128347200.00</b>	<b>128347200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	90318500.00	90318500.00
210202	Тэтгэмжийн даатгал	9507100.00	9507100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7605700.00	7605700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1901400.00	1901400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19014500.00	19014500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>59261600.00</b>	<b>59261600.00</b>

210301	Гэрэл, цахилгаан	4464800.00	4464800.00
210302	Түлш, халаалт	42686800.00	42686800.00
210303	Цэвэр, бохир ус	12110000.00	12110000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4701600.00</b>	<b>4701600.00</b>
210401	Бичиг хэрэг	326700.00	326700.00
210402	Тээвэр, шатахуун	1050000.00	1050000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1269800.00	1269800.00
210404	Ном, хэвлэл	746800.00	746800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1308300.00	1308300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>73393000.00</b>	<b>73393000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	422400.00	422400.00
210502	Хоол, хүнс	69782700.00	69782700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3187900.00	3187900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1000000.00</b>	<b>1000000.00</b>
210604	Урсгал засвар	1000000.00	1000000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>373400.00</b>	<b>373400.00</b>
210702	Дотоод албан томилолт	373400.00	373400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1066700.00</b>	<b>1066700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	466700.00	466700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9183520.00</b>	<b>4790200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9183520.00	4790200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33887500.00</b>	<b>33887500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33887500.00	33887500.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1256765000.00</b>	<b>1256765000.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1196503400.00</b>	<b>1196503400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1196503400.00	1196503400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>60261600.00</b>	<b>60261600.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	60261600.00	60261600.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>86.00</b>	<b>86.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	56.00	56.00
620003	Үйлчлэх ажилтан	29.00	29.00
620004	Гэрээт ажилтан		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>86.0</b>	<b>86.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	57.00	57.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		

650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	29.00	29.00
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>5169620.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>5169620.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>5169620.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>4393320.00</b>
210401	Бичиг хэрэг		3206594.00
210402	Тээвэр, шатахуун		480000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		604326.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		102400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>776300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		776300.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>5169620.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>5169620.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5169620.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор В.Хуандых гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус сургууль нь 2021 оны хичээлийн жилд " Сурах, сургах үйлийг дэмжин, хоцрогдлыг арилгаж, хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, чанартай зохион байгуулах" зорилготой ажиллаж, дараах үндсэн 12 дэд зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, цахим хичээлийн сан болон идэвхтэй суралцах, суралцагчийн бие даан ажиллах үйлийг дэмжсэн дасгал, даалгаврын сан бүрдүүлж, үр дүнтэй ашиглах;
2. Дижитал технологийг хичээл, сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх, түүнийг үр дүнтэй ашиглахад багш нарын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг чиглүүлж, багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх;
3. Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сурах, хөгжих үйлийг дэмжиж, хичээл, сургалтын үйл ажиллагаанд тэдний оролцоог тэгш хангах, хамтран суралцах соёлыг төлөвшүүлэх;
4. Хичээл, сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг асуудалд бүтээлчээр хандах, шийдлийн эрэл хайгуул хийх, учир шалтгааныг илрүүлэх, асуудал шийдвэрлэх, үнэлгээ, дүгнэлт хийх үйлд чиглүүлэх;
5. Суралцагч бүрийг боловсролд тэгш хамруулах, сургууль завсардахаас сэргийлэх, айдас түгшүүр, сэтгэл зовнил, стрессгүйгээр суралцах, хөгжихөд дэмжлэг үзүүлэх, эрүүл, аюулгүй амьдрах зөв дадал, хэвшил бий болгох үйл ажиллагааг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан үр дүнтэй зохион байгуулах;
6. Багш, ажилтанд стрессээс сэргийлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёл бүрдүүлэх;
7. Хичээл, үйл ажиллагааг улирлын байдлаас үл хамааран гадна орчинд зохион байгуулах боломжийг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах;

8. Дунд, ахлах ангийн суралцагч ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээг төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлэх;

9. Бусад сургуулиудтай харилцан туршлага солилцох, хичээл, сургалтын үйл ажиллагааг хамтран зохион байгуулах замаар үйлчилгээний чанар, үр ашгийг сайжруулах;

10. Сургуулийн үйл ажиллагаа, хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан амжилттай суралцах, хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөлт ажил, арга хэмжээг нутгийн мэргэжлийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, хамтын ажиллагаа түншлэлийг сайжруулах;

11. “Чанартай багшаас-чанартай боловсрол” зарчмыг бодитой хэрэгжүүлэх, багш нарын хандлага, туршлага, мэдлэг боловсролд ахиц гаргах;

12. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Ерөнхий боловсролын 6 дугаар сургуульд 2021 онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019, 2020 оны санхүүгийн бүртгэл анхан шатны баримтад шалгалт хийсэн, Боловсролын газар болон аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцагч нар шалгалт хийсэн байна.

Сургууль нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна. Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1255.9 сая төгрөгөөс 1 хувиар 12.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар 10.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1992.4 сая төгрөгөөр буюу 5 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	3263.9	4039.7	775.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	31179.1	31423.4	244.3
Үндсэн хөрөнгө	295038.1	2286429.8	1991391.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>329481.16</b>	<b>2321892.91</b>	<b>1992411.75</b>
Өр төлбөр	7292.2	12121.0	4828.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	322188.97	2309771.90	1987582.93
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>329481.16</b>	<b>2321892.91</b>	<b>1992411.75</b>

Оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлд 3.3 сая төгрөгийн авлагатай байсан ба тайлант онд тухайн авлагыг барагдуулж оны эцэст хувь хүний орлогын албан татварт 4.0 сая төгрөгөөр шинээр авлагыг үүсгэсэн байна.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 31.4 сая төгрөг болж 0.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь материалын орлого зарлагын гүйлгээтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2286.4 сая төгрөг болж 1991.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.7 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан дуусаагүй барилга 1850.0 сая, нийт 1851.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, сургуулийн эзэмшил газрын эрхийг 160.0 сая төгрөгөөр биет бус хөрөнгөд орлогод авч, үндсэн хөрөнгөнд 20.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өглөг оны эцэст 12.1 сая төгрөг болж 4.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь халаалтын зардлын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2309.8 сая төгрөг болж 1987.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1992.4 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3112.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1851.1 сая төгрөгөөр буюу 146.7 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хөрөнгийн санхүүжилт мөн урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь тайлант онд хөрөнгийн санхүүжилтээр дуусаагүй барилгыг орлого авсантай холбоотой материаллаг хэмжээний өөрчлөлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 18.8 сая төгрөгөөр буюу 1.48 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглахтай холбоотой тогтмол зардлаас түлш, халаалтын зардал, бусад урсгал шилжүүлгээс төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал буюу үдийн цайны зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд засгийн газрын оруулсан капитал дансанд төрийн өмч нэмэгдсэн нь сургуулийн эзэмшил газрын эрхийг биет бус хөрөнгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2020 оны анх батлагдсан төсөв 1256.8 сая төгрөг, тодотгосон төсөв 1256.8 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 44.5 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Үүнд: Цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 132.3 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 17.9 сая төгрөгөөр, тогтмол зардлыг 2.7 сая төгрөгөөр, нормын хувцас, зөөлөн эдлэл 0.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, хоол хүнсний зардлыг 106.8 сая төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллыг 2.0 сая төгрөгөөр анх баталснаас бууруулж тодотгол хийгдсэн байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 150.2 сая төгрөгөөр дутуу суулгасан, нэмэгдэл, урамшлын зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь тайлант онд 1256.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1256.7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1256.7 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 75.6 хувийг цалин, 10.2 хувийг НДШ-ийн зардал, 4.7 хувийг тогтмол зардал, 0.4 хувийг хангамж бараа материалын зардал, 5.8 хувийг норматив зардал, 0.07 хувийг эд хогшил худалдан авах зардал, 0.03 хувийг томилолт, зочны зардал, 0.08 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 2.7 хувийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг зардал тус тус эзэлж байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн тайланг баталгаажуулахаар хийсэн горим сорилын дүнгээр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлуудад цалингийн зардалд 950.7 сая төгрөг, НДШ-ийн зардалд 128.3 сая төгрөг, халаалтын зардалд 59.3 сая төгрөг, урсгал засвар, эм, хоолны зардалд 71.8 сая төгрөг, үдийн цайны зардалд 33.9 сая төгрөг, нийтдээ 1244.0 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт санхүүжилтийн орлого 1256.7 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардал 1244.0 сая төгрөгийг хасахад 12.7 сая төгрөгийн тэвчиж болох зардал байгаа ба тогтоолын дагуу 1.3 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна.

Сургууль нь 2021 онд төсвөөс хэмнэлт гаргаж ажиллаагүй тул Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 5.2 сая төгрөгийн нэмэлт орлого хүлээн авсан байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 4.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 0.8 сая, нийт 5.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль тайлант онд “Эрчим” ХХК-д халаалтын зардалд батлагдсан 42.7 сая төгрөгийг бүрэн төлсөн боловч оны эцэст 12.1 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 4.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь халаалтын зардлын төсвийг сургуулийн төсөвт дутуу суулгасан, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал байна.

## **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

## **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь 2021 онд нийт 1256.7 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1256.7 сая төгрөгийн 100 мэдээллийг хугацаандаа байршуулж, 49 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 2 мэдээлэл буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар итгэл үзүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 1.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар 1.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль 2021 онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1.3 сая төгрөгийг хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь 2021 онд нийт 1256.7 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1256.7 төгрөгийн 100 мэдээллийг хугацаандаа байршуулж, 49 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан. Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын дундаж 66.6 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”; 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн мэдээ, мэдээллийг хугацаандаа байршуулах зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

#### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль	2	1.3					2	1.3		